МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД

Засгийн газрын байр 12, Барилгачдын талбай 3,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.mecc.gov.mn

2026.09.22 № 01/5642
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Тус яаманд ирүүлсэн 2026 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 54 дүгээр албан бичгийн дагуу “Оюу толгой” ХХК-ийн 2025, 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилттэй холбоотой мэдээллийг хүргүүлж байна.

1. Хяналт шалгалт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас “Оюу толгой” ХХК-ийн үйл ажиллагаанд 2025 онд орчны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. Харин 2026 онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын улсын ерөнхий байцаагч нарын хамтран баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. 2025 оны төлөвлөгөөт хяналт шалгалтаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдаагүй хугацаанд үйл ажиллагаа явуулсан нөхцөл тогтоогдож, Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу холбогдох арга хэмжээ авсан. 2026 оны төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдаагүй хугацаанд үйл ажиллагаа явуулсан, байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй, аюултай хог хаягдалтай холбоотой журам зөрчсөн нөхцөлүүд тогтоогдсон. Үүнтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу холбогдох арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлсэн. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газрын хяналтад явуулсан бөгөөд “Оюу толгой” ХХК нь эрх бүхий албан тушаалтны албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч, 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2026 оны 07 дугаар сарын 09-ний өдөр тус яамаар батлуулсан байна.

2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдсан байдал:

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших MV-006709 дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Оюу толгой алт-зэсийн ордын төсөлд 2011–2022 онд ЖЭМР ХХК, Эс И Си ХХК, Натур фрейндли ХХК, Магес консалтант ХХК, Грийнтрендс ХХК зэрэг мэргэжлийн байгууллагаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

Оюу толгой ХХК нь 2011–2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, 2011–2023 оны төлөвлөгөөний биелэлтийн тайланг хянуулсан. Харин 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд туссан байгаль хамгаалах баталгааны хөрөнгө байршуулагдаагүй тул төлөвлөгөөг буцааж, батлаагүй байна. 2026 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдаагүй хугацаанд үйл ажиллагаа явуулсан нөхцөл хяналт шалгалтаар тогтоогдож, эрх бүхий албан тушаалтнаас өгсөн албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсний үндсэн дээр 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2026 оны 07 дугаар сарын 09-ний өдөр тус яамаар батлуулсан.

3. Байгаль хамгаалах баталгааны хөрөнгийн талаар:

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газраас тогтоосон албан шаардлагын хүрээнд аудитын биелэлтийн тайлангийн зөрүүг шийдвэрлэж, н/60/АО160114, ГНАГ-2024/08-ГА дугаартай албан шаардлагын дагуу Оюу толгой ХХК-ийн 2010–2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд туссан байгаль хамгаалах зардлын 50 хувьтай тэнцэх 6,404,800,000 төгрөгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулах шаардлагын биелэлтийг хангасан.

Байгаль орчны нөхөн сэргээх баталгаа дансанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгө Оюу толгой ХХК нэрээр 2010 оны 06 дугаар сарын 25-ны өдөр 6,880,000, 2011 оны 05 дугаар сарын 20-ны өдөр 187,720,000, 2012 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр 170,080,000, 2013 оны 06 дугаар сарын 14-ний өдөр 378,050,000, 2014 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 109,700,000, 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 20,255,000, 2024 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр 957,565,000, 2025, 2026 онд 9,942,779,500 буюу нийт 11,773,029,500.00 төгрөгийн барьцаа хөрөнгө тус тус байршуулсан байна.

Байгаль орчин, уур амьсгалын
өөрчлөлтийн яам
Сайд
Ц.Сандаг-Очир
2026.09.22 11:09